

Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны
даргын 202.... оны дугаар сарын -ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА, ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЗАРЛАГЫН АНГИЛЛЫГ ТОДОРХОЙЛОН ТАЙЛАГНАХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журмын зорилго нь улс төрийн намын (цаашид “Нам” гэх) санхүүгийн тайлан бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлох, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь нэгдүгээр хавсралт “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”, хоёрдугаар хавсралт “Санхүүгийн тайлангийн маягт”, гуравдугаар хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, дөрөвдүгээр хавсралт “Үйл ажиллагааны товч тайлангийн маягт”-аас бүрдэнэ.

1.3.Энэ журам, журмын хавсралтыг Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бүх нам ба намын харьяа байгууллага дагаж мөрдөнө.

1.4.Намын санхүүгийн тайланг хугацаанд нь, үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг намын дарга, намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан хүлээнэ.

1.5.Нам, түүний харьяа байгууллага санхүүгийн тайлангаа Улс төрийн намын тухай хуульд заасан хугацаанд сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

1.6.Намын нэгдсэн тайланд намын төв байгууллагын тайланг доод шатны намын салбар нэгжийн тайлангийн хамт тус тус хавсаргана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НАМЫН ХӨРӨНГӨ

Хоёр. Намын хөрөнгө

2.1.Намын хөрөнгөд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилан төлсөн зардал/тооцоо, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг хамааруулна.

2.2.Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь намд орох магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартайгаар хэмжих боломжтой үед хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Гурав. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

3.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касст байгаа бэлэн мөнгө, банкинд байршуулсан мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (чек гэх мэт), хуримтлал хамаарна.

3.2.Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

3.3.Нам нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг эзэмшиж, захиран зарцуулах эрх үүссэн нөхцөлд хүлээн зөвшөөрнө.

3.4.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бүртгэх ба тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр илэрхийлж, тайлагнана.

3.5.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн орлогыг хүлээн авах үед дараах дансны бичилтийг хийнэ.

Дебет: Харилцах данс

Кредит: Холбогдох орлогын данс /Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг/

3.6.Нам нь үйл ажиллагааны зардал, хуримтлуулсан өглөг, бусад өглөгийг харилцах данснаасаа төлөх үед:

Дебет:Холбогдох зардлын данс, эсхүл өглөг

Кредит:Харилцах данс

3.7.Касст байгаа бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ хийх үед дараах дансны бичилтийг хийнэ.

3.7.1.харилцахаас касст бэлэн мөнгө авах үед:

Дебет:Бэлэн мөнгө

Кредит:Харилцах данс

3.7.2.бэлэн мөнгө харилцах дансанд тушаах үед:

Дебет:Харилцах данс

Кредит:Бэлэн мөнгө

Дөрөв. Авлага

4.1.Авлага нь бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн тооцооны дүн юм. Тухайлбал үүнд ажиллагсад болон хуулийн этгээд, иргэнээс авах авлага бусад тооцооны авлага гэх мэт авлага багтана.

4.2.Авлагыг найдвартай хэмжиж болох, нэхэмжлэх үйлдэн хариуцагч талд шилжүүлснээр мөнгө буюу бусад хөрөнгө хүлээн авах эрхтэй болсон нөхцөлд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.

4.3.Ажил гүйлгээний үр дүнд үүссэн авлагыг бүртгэх үед:

Дебет:Авлагын холбогдох данс

Кредит:Орлого /нэр төрлөөр/

авлага мөнгөөр төлөгдөх үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Авлага /нэр төрлөөр/

авлага мөнгөн бус хөрөнгөөр тооцон төлөгдөх үед

Дебет: Хөрөнгийн холбогдох данс

Кредит: Авлага /нэр төрлөөр/

4.4.Татвар, шимтгэлийн авлага дансыг татварын төрөл тус бүрээр данс нээж бүртгэнэ. Тайлант хугацаанд тухайн төрлийн татварын авлага ба өр төлбөрийн дансны аль алинд нь гүйлгээ гарсан үед тайлант хугацааны эцэст үлдэгдэл багатай дансыг үлдэгдэл ихтэй данс руу хааж үлдэгдэлгүй болгоно.

4.4.1.татвар, шимтгэлийг урьдчилан төлсөн бол:

Дебет:Татварын авлага/ НДШ-ийн авлага

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

4.4.2.тайлант хугацааны эцэст тухайн төрлийн татварын авлага ба өр төлбөрийн дансыг хооронд нь хаахад:

Дебет:Татварын өглөг/ НДШ-ийн өглөг

Кредит:Татварын авлага / НДШ-ийн авлага

4.5.Авлагыг ирээдүйд хүлээн авахаар тооцсон цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн байдлын тайланд толилуулна. Иргэн, хуулийн этгээдээс өгөхөөр амласан хандивыг авлагаар бүртгэхгүй.

4.6.Авлагын цэвэр боломжит үнэ цэнэ нь төлөгдөх боломжтой авлагын дүнгээр тодорхойлогдох ба гэрээнд заагдсан авлагын нийт дүнгээс найдваргүй гэж үзсэн, төлөгдөх боломжгүй авлагыг хассан дүн юм.

4.7. Нам нь дансны авлагын үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа өмнөх жилүүдийн туршлагад үндэслэн авлагын эргэн төлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан хувь хэмжээг тогтоож болно.

4.8. Дансны авлагад найдваргүй авлагын нөөцийг байгуулсан үед:

Дебет: Найдваргүй авлагын зардал

Кредит: Найдваргүй авлагын нөөц

4.9. Найдваргүй авлагын нөөцийг буцаах бичилт хийхдээ тухайн тайлангийн үед хүлээн зөвшөөрсөн зардлыг бууруулах ба илүү гарсан хэсгийг бусад олзоор бүртгэнэ.

Дебет: Найдваргүй авлагын нөөц

Кредит: Найдваргүй авлагын зардал/ Бусад олз

4.10. Найдваргүй авлагыг данснаас хасах үед:

Дебет: Найдваргүй авлагын нөөц

Кредит: Авлага /нэр төрлөөр/

() найдваргүй гэж данснаас хассан авлага эргэн төлөгдсөн үед:

Дебет: Авлага /нэр төрлөөр/

Кредит: Найдваргүй авлагын нөөц

Дебет: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Авлага /нэр төрлөөр/

Тав. Бусад эргэлтийн хөрөнгө

5.1. Бусад эргэлтийн хөрөнгөд урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал зэрэг бусад эргэлтийн хөрөнгө хамрагдана.

5.2. Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ.

5.3. Урьдчилж төлсөн зардал, тооцоог төлсөн мөнгөн дүнгээр хэмжинэ.

5.4. Үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл урьдчилж төлсөн зардалд бүртгэн, зардлыг хэрэгжсэн үед нь тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө. бүртгэнэ.

5.4.1. бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн зардлыг бүртгэх үед:

Дебет: Урьдчилж төлсөн зардал

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

5.4.2. урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Урьдчилж төлсөн зардал

5.5. Бараа, үйлчилгээг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

5.5.1. бараа, үйлчилгээний төлбөрийг урьдчилж төлөх үед:

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

5.5.2. урьдчилгаа төлбөрийн тооцоо хийж, дансыг хаах үед:

Дебет: Хөрөнгийн хөрөнгийн данс/Зардлын холбогдох данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

5.6. Ажиллагсад албан үүргээ гүйцэтгэх буюу гадаад, дотоодод албан томилолт, сургалт, зөвлөгөөнд хамрагдах, салбар нэгж рүү ажиллах зэрэгт зориулан удирдлагын шийдвэрийн дагуу олгосон урьдчилгаа мөнгийг дараа тайлангийн тооцоо дансанд бүртгэн, тооцоог хийнэ.

5.6.1. дараа тайлангийн тооцоог олгох үед:

Дебет: Дараа тайлангийн тооцоо

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

5.6.2.урьдчилгаанд олгосон мөнгөний зарцуулалтын баримтыг үндэслэн тооцоог хийж, дараа тайлангийн тооцоо дансыг хаах үед:

Дебет:Зардлын холбогдох данс

Кредит:Дараа тайлангийн тооцоо

5.6.3.дараа тайлангийн тооцоо дансны хувьд тооцоо үүссэн ажилтан бүрээр данс нээн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, тухайн ажилтны хувьд үүссэн тооцоо, үлдэгдлийг сар бүр тохируулж байна.

5.6.4.урьдчилгаа мөнгө илүү гарсан тохиолдолд ажилтнаас авлага үүсгэх, эсхүл төлүүлэх үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/Ажиллагчдаас авах авлага

Кредит:Дараа тайлангийн тооцоо

5.6.5.урьдчилгаа мөнгө дутуу тооцсон тохиолдолд ажилтанд өгөх өглөг үүсгэх, эсхүл төлөх үед:

Дебет:Дараа тайлангийн тооцоо

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Ажиллагчдад өгөх өглөг

5.7.Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа, хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө бараа материалд хамрагдана.

Зургаа. Үндсэн хөрөнгө

6.1.Үндсэн хөрөнгө гэдэгт бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа, нэг буюу түүнээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй биет шинжтэй хөрөнгийг ойлгоно.

6.2.Үндсэн хөрөнгийг нийтлэг шинж чанар, зориулалтаар нь эзэмшлийн газар, барилга байгууламж, ажлын байрны тоноглол, техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгө гэж ангилна.

6.3.СТОУС-н дагуу хөрөнгийн тодорхойлолтод нийцэн, хүлээн зөвшөөрөх шалгуурыг бүрэн хангасан бөгөөд худалдан борлуулах зориулалтгүй хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

6.4.Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ.

6.5.Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

6.6.Хөрөнгийн өгөөжийг хэрхэн хүртэхийг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлагын бодлого, шийдвэрээр үндсэн хөрөнгийг ашиглах хугацааг тогтоож, элэгдэл тооцох тохиромжтой аргыг сонгоно. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг тооцохдоо хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст үлдэх үнэ цэнийг хасаж тодорхойлно.

6.6.1.хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна.

6.6.2.элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй.

6.6.3.Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах бүртгэлийн бодлого нь татварын хуулиар тогтоосон хувь хэмжээнээс зөрүүтэй бол зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

6.7.Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох аргыг тайлант үе бүрийн эцэст эргэн нягталж, хэрэв тэдгээрийг өөрчлөх тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн гүйцээх горимоор бүртгэнэ.

6.8.Санхүүгийн тайлангийн өдрөөр үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тогтооно. Хэрэв үнэ цэнэ буурсан гэх нотолгоо байгаа бол тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолж, дансны үнэтэй харьцуулан, үнэ цэнийн бууралтыг тодорхойлно.

6.9.Хөрөнгийн нөхөгдөх дүн гэж хөрөнгийн буюу мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн болон ашиглалтын үнэ цэнийн аль ихийг хэлнэ. Хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

6.10.Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, санхүүгийн тайланд тусгана.

6.11.Дахин үнэлгээ хийх давтамж нь уг дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаардаг. Үндсэн хөрөнгийн нэг анги доторх зүйлсийг нэгэн зэрэг дахин үнэлнэ.

6.12.Үндсэн хөрөнгийн онцлог шинж болон бизнесийн үйл ажиллагааны явцаас бусад тохиолдолд ховорхон арилжаалагддаг гэсэн шалтгаанаар хөрөнгийн бодит үнэ цэнээр үнэлэх боломжгүй бол өртгийн аргаар бодит үнэ цэнийг үнэлж болно.

6.13.Үндсэн хөрөнгийг худалдан авах, бэлтгэх үед түүний анхны өртөг нь хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассан үнэ, импортын татвар ба буцаан үл олгогдох худалдан авалтын татвар, хөрөнгийг ашиглах боломжтой байршил болон нөхцөл байдалд авчрахтай шууд хамааралтай зардал, үндсэн хөрөнгийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах тооцоолсон зардал зэргээс бүрдэнэ:

Дебет:Үндсэн хөрөнгийн холбогдох данс

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны өглөг

6.14.Үндсэн хөрөнгийг сайжруулах, өөрчлөх, сэргээн босгох, нөхөн орлуулах, засварлах зэрэг өмчлөлийн хугацаанд гарсан зардал нь хөрөнгийн ашиглах хугацааг уртасгах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, эсхүл бүтээгдэхүүний чанарыг сайжруулахаар байвал хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Энэ шинжийг агуулаагүй бусад бүх засвар, үйлчилгээний урсгал зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэнэ.

6.14.1.үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг капиталжуулсан үед:

Дебет:Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

6.14.2.үндсэн хөрөнгийн засвар, үйлчилгээний зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэх үед:

Дебет:Засварын зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

6.15.Хөрөнгийг ашиглагдах боломжит хугацааны туршид тухайн хөрөнгийн анхны өртгөөс элэгдэл тооцож, өртөг зардалд системтэйгээр шингээнэ. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй.

6.15.1.үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоолсон үед:

Дебет:Элэгдлийн зардал

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

6.15.2.үнэ цэнийн бууралтын гарзыг бүртгэхдээ:

Дебет:Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз

Кредит:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

6.16.Үндсэн хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акталж устгах үед түүний анхны өртгийн хэмжээгээр данснаас хасах бөгөөд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дансыг хаасан байна.

6.16.1.үндсэн хөрөнгийг дансны үнээс нь доогуур үнээр борлуулсан бол үндсэн хөрөнгө борлуулсны гарзыг хүлээн зөвшөөрнө:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад авлага

Дебет:Хуримтлагдсан элэгдэл

Дебет:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Дебет:Хөрөнгө данснаас хассаны гарз

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

6.16.2.үндсэн хөрөнгийг дансны үнээс нь илүү үнээр борлуулсан бол үндсэн хөрөнгө борлуулсны олзыг хүлээн зөвшөөрнө:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад авлага

Дебет:Хуримтлагдсан элэгдэл

Дебет:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит:Хөрөнгө данснаас хассаны олз

6.17.Үндсэн хөрөнгийн зүйлийг ижил бус төрлийн үндсэн хөрөнгийн зүйл, эсхүл бусад хөрөнгөөр солих, хэсэгчлэн солих замаар олж авч болно.

6.17.1.үндсэн хөрөнгүүдийн солилцоог арилжааны шинжтэй гэж үзвэл авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэнэ. Хэрэв авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь өгсөн хөрөнгийн дансны үнээс их бол зөрүүгээр олз бүртгэнэ:

Дебет:Үндсэн хөрөнгө (авсан)

Дебет:Хуримтлагдсан элэгдэл (өгсөн хөрөнгийн)

Кредит:Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз

Кредит:Үндсэн хөрөнгө (өгсөн)

6.17.2.хэрэв авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь өгсөн хөрөнгийн дансны үнээс бага бол зөрүүгээр гарз бүртгэнэ:

Дебет:Үндсэн хөрөнгө (авсан)

Дебет:Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз

Дебет:Хуримтлагдсан элэгдэл (өгсөн хөрөнгийн)

Кредит:Үндсэн хөрөнгө (өгсөн)

6.17.3.харин үндсэн хөрөнгийн солилцоо арилжааны бус шинжтэй, эсхүл авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ мэдэгдэхгүй байвал авсан хөрөнгийг өгсөн хөрөнгийн үлдэгдэл өртгөөр хэмжиж, бүртгэх ба энэ үед олз, гарз үүсэхгүй:

Дебет:Үндсэн хөрөнгө (авсан)

Дебет:Хуримтлагдсан элэгдэл (өгсөн хөрөнгийн)

Кредит:Үндсэн хөрөнгө (өгсөн)

6.18.Үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг дор дурдсан аргын аль нэгээр бүртгэнэ:

6.18.1.Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны нийт үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлж дахин тооцох ба ингэснээр дахин үнэлгээний дараах хөрөнгийн дансны үнэ нь дахин үнэлсэн дүнтэй тэнцүү болно. Энэ аргыг ихэвчлэн элэгдүүлсэн өртгөөс индексийн тусламжтайгаар хөрөнгийг дахин үнэлэх үед хэрэглэдэг.

Дебет:Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит:Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Кредит:Дахин үнэлгээний нэмэгдэл

6.18.2.Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны өртгөөс хасах ба гарсан цэвэр дүнг хөрөнгийн дахин үнэлсэн дүн хүртэл үнэлж тооцно.

Дебет:Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

Дараа нь үндсэн хөрөнгийн өсөлтийг бүртгэнэ:

Дебет:Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит:Дахин үнэлгээний нэмэгдэл

6.19.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэ өссөн тохиолдолд уг өсөлтийг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Гэхдээ тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг өмнө нь ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрсөн бол тэр хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг мөн адил ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

6.19.1.дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгийн үнэлгээний өсөлтийг бүртгэх үед:

Дебет:Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит:Дахин үнэлгээний нэмэгдэл

6.19.2.дараагийн дахин үнэлгээгээр тухайн хөрөнгийн үнэлгээ буурсан бол:

Дебет:Дахин үнэлгээний нэмэгдэл

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

6.19.3.дахин үнэлсэн хөрөнгийг данснаас хассан тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг хуримтлагдсан үр дүн дансанд хаана:

Дебет:Дахин үнэлгээний нэмэгдэл

Кредит:Хуримтлагдсан үр дүн

6.20.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзаар бүртгэнэ. Гэхдээ тухайн хөрөнгийн өмнөх дахин үнэлгээний нэмэгдлийн кредит дүнгийн хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлого хэсэгт хүлээн зөвшөөрч болно. Бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрсөн бууралт нь өмчийн хэсэг дэх дахин үнэлгээний нэмэгдэл дансны хуримтлагдсан дүнг бууруулна.

6.20.1.дахин үнэлгээний үр дүнд үлдэгдэл өртөг буурсан тохиолдолд:

Дебет:Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз

Кредит:Үндсэн хөрөнгө

6.20.2.харин дараагийн дахин үнэлгээгээр тухайн хөрөнгийн үнэлгээ өссөн бол:

Дебет:Үндсэн хөрөнгө

Кредит:Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн олз

6.20.3.дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг дахин үнэлгээний бууралт гэж үзнэ:

Дебет:Дахин үнэлгээний нэмэгдэл

Кредит:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

6.20.4.хэрэв хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь дахин үнэлгээний нэмэгдлээс хэтэрсэн бол хэтэрсэн зөрүүгээр:

Дебет:Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз

Кредит:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

6.21.Үндсэн хөрөнгийг ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй буюу ашиглах боломжгүй болсон, данснаас хассан үед нь санхүүгийн тайлангаас хасна.

6.21.1.элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг ашиглалтаас хасах буюу актлах үед:

Дебет:Хуримтлагдсан элэгдэл

Дебет:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

6.21.2.элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй хөрөнгийг ашиглалтаас хасах буюу актлах үед:

Дебет:Хуримтлагдсан элэгдэл

Дебет:Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

Дебет:Хөрөнгө данснаас хассаны гарз

Кредит:Холбогдох үндсэн хөрөнгө

6.22.Нам нь барилга байгууламжийг өөрөө барьж, бий болгож байгаа үед тухайн барилгын гүйцэтгэлийн ажил дуусаж үндсэн хөрөнгөнд шилжүүлэх хүртэлх хугацаанд уг барилгатай холбоотой гарсан бүх зардлыг хуримтлуулан дуусаагүй барилгаар бүртгэж, тайлагнана.

6.23.Бүтээн босгож буй хөрөнгийг олж авах, барилгын ажлыг гүйцэтгэх, үйлдвэрлэхтэй шууд хамааралтай зээлийн зардал нь тухайн хөрөнгийн өртгийн тодорхой хэсгийг бүрдүүлдэг. Зээлийн өртөгт үр ашигт хүүгийн аргаар тооцсон зээлийн хүү, санхүүгийн түрээсийн хүү, гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлийн ханшийн зөрүү зэрэг багтана.

6.24.Нам нь өөрийн барилга байгууламж барих, бүтээн босгохтой шууд холбоотой гарсан зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулна. Хөрөнгийг барьж босгох үйл явц зогссон, эсхүл бүрэн дууссан үед зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.

6.25.Тайлангийн үед капиталжуулсан зээлийн өртгийн дүн нь тайлант хугацаанд гарсан зардлаас хэтрэхгүй. Тайлангийн үеийн бодит зээлийн зардлаас тэр зээлийн богино хугацаат хөрөнгө оруулалтын орлогыг хасаж, капиталжуулах зардлыг тооцно.

6.25.1.барилга байгууламжийн холбогдох өртгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулах үед:

Дебет:Дуусаагүй барилга

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны өглөг

6.25.2.зээлийн эх үүсвэрээр олж бэлтгэсэн хөрөнгийн өртгийг капиталжуулахдаа:

Дебет:Дуусаагүй барилга

Кредит:Хүүгийн зардал

6.25.3.барилгын ажил дуусаж, мэргэжлийн байгууллагаас ашиглах зөвшөөрөл авсан бол дуусаагүй барилгаа үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж бүртгэнэ:

Дебет:Барилга байгууламж

Кредит:Дуусаагүй барилга

Долоо. Биет бус хөрөнгө

7.1.Биет бус хөрөнгөд биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгийг ойлгоно.

7.2.Хөрөнгө нь дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:

7.2.1.тухайн намаас тусгаарлах буюу салган хувааж болох, эсхүл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслэх, солилцох боломжтой байх;

7.2.2.гэрээний болон хуулиар олгогдсон эрхийг шилжүүлж болох буюу тухайн байгууллагаас өөр бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран тухайн гэрээний буюу бусад хуулийн эрхээс үүссэн байх.

7.3.Биет бус хөрөнгөд нэгээс дээш тайлант үеийн хугацаанд үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй, патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг, тодорхой дүнтэй программ хангамж, хөгжүүлэлтийн явцад бий болсон болон бусад биет бус хөрөнгө хамаарна.

7.4.Биет бус хөрөнгийг тухайн хөрөнгөд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь уг намд орох өндөр магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах шалгуурыг хангаж байвал хүлээн зөвшөөрнө.

7.5.Хэрэв тухайн хөрөнгө нь бусад хөрөнгийн хамтаар ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгдөг тохиолдолд тухайн хөрөнгөөс хүртэх өгөөжийг тусад нь тооцох боломжтой бол тодорхойлж болох хөрөнгө гэж үзэж тусад нь хөрөнгөөр бүртгэх ба харин боломжгүй бол бусад хөрөнгийн хамт бүртгэнэ.

7.6.Нам нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд хөрөнгийг бий болгох үе шатыг судалгааны ба хөгжүүлэлтийн үе шат гэж ангилаад, дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

7.6.1.судалгааны зардлыг гарсан тухай бүрд нь тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

7.6.2.хэрэв биет бус хөрөнгийг бий болгох судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатаас ялгаж чадахгүй байгаа бол зарцуулсан зардлыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан гэж үзээд зардлаар хүлээн зөвшөөрнө.

7.6.3.биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй хөгжүүлэлтийн зардлыг гарсан тухай бүрд зардлаар, харин шалгуурыг хангасан тохиолдолд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

7.7.Дараах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хөгжүүлэлтээс бий болох биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө:

7.7.1.хөгжүүлэлтийг бүрэн дуусгах техникийн үндэслэлтэй байх;

7.7.2.биет бус хөрөнгийг бүрэн дуусгах зорилготой байх;

7.7.3.ашиглах, эсхүл борлуулах боломжтой байх;

7.7.4.ирээдүйн магадлалт эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг хэрхэн бий болгох, дотооддоо ашиглах бол тухайн биет бус хөрөнгө ач тустай гэдгийг батлах;

7.7.5.хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ба тухайн биет бус хөрөнгийг ашиглах, эсхүл борлуулах зохих техникийн, санхүүгийн болон бусад нөөц бэлэн боломжтой байх;

7.7.6.хөгжүүлэлтийн явцад уг биет бус хөрөнгөд хамаарах зарлагыг найдвартай хэмжих чадвар боломжтой байх.

7.8.Санхүүгийн түрээсээр хөрөнгө авсан бол түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар түрээсийн хөрөнгийг хэмжинэ. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээслэгчийн ашиглаж буй нуугдмал хүү байна.

7.9.Биет бус хөрөнгийн хорогдол:

7.9.1.биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаанд тохиромжтой аргаар хорогдуулна. Хэрэв тохиромжтой аргыг тодорхойлоогүй бол шулуун шугамын аргаар хорогдуулна.

7.9.2.биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй, үнэ цэнийн бууралтыг тайлант үе бүр шалгаж, бүртгэнэ.

7.10.Шаардлагатай гэж үзвэл биет бус хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэж болно. Биет бус хөрөнгийн идэвхтэй зах зээлийн үнэлгээг хийхэд идэвхтэй зах зээл байдаггүй тул биет бус хөрөнгийг дахин үнэлэх нь маш ховор.

7.11.Биет бус хөрөнгийг ашигласнаар цэвэр мөнгөн орлого бий болгохоор хүлээгдэж буй хугацааг урьдчилан тодорхойлох боломжгүй бол тухайн биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойгүй гэж үзнэ.

7.12.Биет бус хөрөнгөд хорогдол тооцоогүй үед ашиглалтын хугацааг тайлант үеийн төгсгөлд хянаж, тухайн хөрөнгийн тодорхойгүй ашиглагдах хугацааг хэвээр үлдээх шалтгаан байгаа эсэхийг тогтооно. Ийм шалтгаан байхгүй бол тодорхойгүй ашиглалтын хугацааг тодорхой хугацаагаар сольж, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзээд, бүртгэлд тусгана.

7.13.Биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

7.13.1.худалдаж авсан биет бус хөрөнгийг өртгөөр нь үнэлж, бүртгэнэ:

Дебет:Биет бус хөрөнгө

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны өглөг

7.13.2.Биет бус хөрөнгийн хорогдлын зардлыг хуримтлуулахад:

Дебет:Хорогдлын зардал

Кредит:Хуримтлагдсан хорогдол

7.14.Биет бус хөрөнгийг олж бэлтгэх, бусад хөрөнгөөр солилцох, холбогдох дараа үеийн зардал, дахин үнэлгээний загвар, үнэ цэнийн бууралт, данснаас хасах зэргийг энэ журмын “Үндсэн хөрөнгө” бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨР ТӨЛБӨР

Найм. Өр төлбөр

8.1.Өр төлбөр гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр буюу ихэнхдээ бусад этгээдэд мөнгө, бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийг ойлгоно.

8.2.Өр төлбөрт эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн, татварын, хойшлогдсон орлого, борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд хамаарах өр төлбөр, салбар хоорондын тооцоо, түрээсийн, даатгалын гэх мэт бусдад өгөх өглөг хамрагдана.

8.3.Нам нь гэрээ, хэлцэлд зааснаар, эсхүл хуулийн дагуу үүрэг хүлээсэн үед холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

8.4.Өр төлбөрийг төлөх, эсхүл төлөгдсөн дүнгээр хэмжиж бүртгэлд тусгана.

8.5.Өр төлбөрийг барагдуулахаар таамаглаж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үед өр төлбөр үүсгэж хүлээн авсан хөрөнгийн дүнгээр, эсхүл уг өр төлбөрийг барагдуулахад төлөх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр өр төлбөрийг үнэлнэ.

8.6.Намын үйл ажиллагаатай холбоотойгоор хуулийн этгээд, иргэнтэй хийх тооцоог өглөг дансаар бүртгэнэ.

8.6.1.хөрөнгө, бараа, үйлчилгээг зээлээр худалдан авах үед:

Дебет:Хөрөнгийн холбогдох данс/ Зардлын холбогдох данс

Кредит:Бусад өглөг

8.6.2.зардлыг хуримтлуулан өглөг бүртгэх үед:

Дебет:Зардлын холбогдох данс

Кредит:Бусад өглөг

8.6.3.зээлээр авсан бараа, үйлчилгээний үнэ болон хуримтлуулсан өглөгийг төлөх үед:

Дебет:Бусад өглөг

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

8.7.Хойшлогдсон орлого гэж СТОУС-ын шаардлагын дагуу хүлээн зөвшөөрөлтийг нь хойшлуулсан бөгөөд хараахан орлого гэж тооцоогүй өр төлбөрийг хэлнэ.

8.7.1.орлогыг хойшлуулан бүртгэх үед:

Дебет:Холбогдох хөрөнгө, өр төлбөрийн данс

Кредит:Хойшлогдсон орлого

8.7.2.хойшлогдсон орлогыг хэрэгжүүлэн, хүлээн зөвшөөрч бүртгэх үед:

Дебет:Хойшлогдсон орлого

Кредит:Холбогдох орлогын данс

8.8.Зогсоосон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийг худалдан борлуулахтай зэрэгцэн өр төлбөрийг барагдуулж байгаа тохиолдолд СТОУС 5-ын дагуу уг өр төлбөрийг борлуулах зорилготой өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

8.8.1.өр төлбөрийг хөрөнгийн хамтаар шилжүүлэхээр тусгаарлан бүртгэх үед:

Дебет:Холбогдох өр төлбөрийн данс

Кредит:Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр

8.8.2.борлуулах зорилготой өр төлбөрийг шилжүүлснээр мөнгө төлөх үед:

Дебет:Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НАМЫН ОРЛОГО

Ес. Намын орлого

9.1.Хөрөнгийн өсөлт, эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө.

9.2.Олз гэж үйл ажиллагааны явцад үүсэж болох, орлогын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Тухайлбал, олзонд эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах үеийн олз, хэрэгжсэн ба хэрэгжээгүй олз багтана.

9.3.Орлогыг хүлээн авсан мөнгө, эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр хэмжинэ.

9.4.Орлогод намын гишүүний болон сонгуульт гишүүний татвар, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг, иргэн, хуулийн этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив, намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар олсон орлого, төслийн санхүүжилтийн орлого болон хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бусад орлого, олз хамрагдана.

Арав. Намын гишүүний татвар

10.1.Намын гишүүний болон намын сонгуульт гишүүний татвар төлөгдөх үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Намын гишүүний татварын орлого

Арван нэг. Төрийн санхүүжилт

11.1.Төрийн санхүүжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэх үед:

Дебет:Авлагын холбогдох данс

Кредит:Төрийн санхүүжилтийн орлого

Төрийн санхүүжилт мөнгөөр орж ирсэн үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Авлагын холбогдох данс

Арван хоёр. Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг

12.1.Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгт Улс төрийн намын тухай хуулийн 30.1-д зааснаар дараах дэмжлэг хамаарна:

12.1.1.төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах;

12.1.2.намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гаргасан хуваарийн дагуу 30 минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх.

Дебет:Холбогдох зардал /Түрээсийн, сурталчилгааны зардал/

Кредит: Төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэгийн орлого

Арван гурав. Хандив

13.1.Иргэн, хуулийн этгээдээс эргэн төлөгдөх нөхцөлгүй хүлээн авсан хөрөнгийг хандивын орлогоор бүртгэнэ. Хандивыг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

13.2.Нам тухайн намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах үнэ зах зээлийн дундаж ханшаас их байвал илүү гарсан хэсгийг намд өгсөн хандивт тооцож бүртгэнэ.

13.3.Хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна.

13.4.Нам Улс төрийн намын тухай хуулийн 34.6-д заасан этгээдээс өгсөн хандивыг хандиваар бүртгэхгүй бөгөөд үүнийг сонгуулийн төв байгууллагад төлөх өглөгөөр бүртгэнэ.

Арван дөрөв. Мөнгөн хандив

14.1.Мөнгөн хандивыг зөвхөн данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр намын дансанд хүлээн авна. Мөнгөн хандивыг харилцах дансанд хүлээн авсан үед:

Дебет: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Мөнгөн хандивын орлого

14.2. Нам нь хандив өгсөн иргэний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр, хандивын хэмжээ, хандивыг хүлээн авсан он, сар, өдрийг цахим хуудсандаа хайлт хийх боломжтой нээлттэй өгөгдлийн санд улирал тутам байршуулж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх бөгөөд уг мэдээллийг намын санхүүгийн тайланд тодруулна.

Арван тав. Мөнгөн бус хандив

15.1.Мөнгөн бус хандивт Улс төрийн намын тухай хуулийн 33.3-т зааснаар үнэ төлбөргүйгээр, эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглах, эзэмших, үйлчилгээ авах, төлбөрийн чөлөөлөлт, хөнгөлөлт эдлэх, арга хэмжээний зардлыг бусдаар төлүүлэх, ивээн тэтгүүлэх зэрэг хамаарна.

15.2.Нам тодорхой зардал, арга хэмжээг бусдаар санхүүжүүлсэн, эсхүл ивээн тэтгүүлсэн тохиолдолд холбогдох зардлыг нь хүлээн зөвшөөрсөн үед мөнгөн бус хандивын орлогыг хүлээн зөвшөөрнө.

15.2.1.тодорхой зардал, арга хэмжээг бусдаар санхүүжүүлэх, эсхүл ивээн тэтгүүлж төлбөрөөс чөлөөлөгдсөн, хөнгөлүүлсэн үнийн дүнгээр:

Дебет:Бусад зардал, /арга хэмжээний зардал/

Кредит:Төлбөрөөс чөлөөлөгдсөн, хөнгөлөгдсөн хандивын орлого

15.3.Нам үйлчилгээ үзүүлсний орлогыг СТОУС 15-н дагуу хүлээн зөвшөөрөх шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

15.14.Үйлчилгээ үзүүлэхдээ холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй тохиолдолд нөхөн төлөгдөх зөвхөн зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

Арван зургаа. Намтай холбоотой хэвлэл, сурталчилгааны материал болон өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар орлого

16.1.Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд нам нь хэвлэл, сурталчилгааны материал зэрэг бараа борлуулсан үед бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө.

16.1.1.барааны өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн;

16.1.2.тухайн борлуулсан барааны өмчлөл болон хяналт шилжсэн;

16.1.3.орлогын дүнг найдвартай хэмжиж боломжтой;

16.1.4.ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай;

16.1.5.ажил гүйлгээний гарсан, эсхүл гарах зардлыг найдвартай хэмжих боломжтой.

16.2.Намын хэвлэл, сурталчилгааны материал зэрэг бараа, материалыг борлуулсны орлогыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) хэвлэл, сурталчилгааны болон бараа материалыг борлуулах үед:

Дебет:Бараа борлуулсны авлага/Дансны авлага

Кредит: Хэвлэл, сурталчилгааны орлого /бусад орлого/

Дебет: Хэвлэл, сурталчилгааны зардал / Бараа материалын зардал/

Кредит:Бараа материал /нэр төрлөөр/

(б) Нэхэмжилсэн авлагыг хүлээн авах үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Бараа борлуулсны авлага/Дансны авлага

16.3.Бусад орлого, олзонд хөрөнгө борлуулсан, данснаас хассаны олз, гадаад валютын ханшийн зөрүүний олз, бусад орлого хамрагдана.

16.3.1.хөрөнгөө үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн гэрээний дагуу түрээсийн орлогыг бүртгэх үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны авлага

Кредит:Түрээсийн орлого

16.3.2.үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, бусад хөрөнгийг олзтойгоор данснаас хассан, борлуулсан үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны авлага

Дебет:Хуримтлагдсан элэгдэл, хорогдол, үнэ цэнийн бууралт

Кредит:Хөрөнгийн холбогдох данс

Кредит:Хөрөнгө борлуулсан, данснаас хассаны олз

16.3.3.хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийг тохируулан бүртгэх үед олз үүссэн бол:

Дебет:Хөрөнгийн холбогдох данс

Кредит:Хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн олз

16.4.Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад үйл ажиллагааг НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* -ийн дагуу бүртгэнэ.

16.5.Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох Монголбанкны албан ханшаар хөрвүүлж, бүртгэлийн валютаар бүртгэнэ.

16.6.Гадаад валютаарх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(а) Гадаад валютаарх авлагыг валютын ханш өссөн үед цуглуулсан:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Гадаад валютын ханшийн зөрүүний олз

Кредит:Авлага /нэр төрлөөр/

(г) Гадаад валютаарх өглөгийг валютын ханш буурсан үед төлөхөд:

Дебет:Өглөг /нэр төрлөөр/

Кредит:Гадаад валютын ханшийн зөрүүний олз

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

16.7.Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг хүлээн авсан өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж, бүртгэнэ.

16.8.Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс нь гадаад валютаарх мөнгөн хөрөнгө болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгөөс бүрдэнэ. Мөнгөн зүйлсийн барагдуулалт, эсхүл мөнгөн зүйлсийн ханшийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн бүх мөнгөн зүйлсийн хувьд тайлан гарах өдрөөрх хаалтын ханшийг ашиглан гадаад валютын ханшийн зөрүүг тооцно.

(а) Валютын ханш өссөн үед мөнгөн зүйлсийн хөрөнгийг нэмэгдүүлж, ханшийн зөрүүний олз бүртгэхэд:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө – гадаад валют/ Авлага

Кредит:Гадаад валютын ханшийн зөрүүний олз

(б) Валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн өр төлбөрийг бууруулж, ханшийн зөрүүний олз бүртгэхэд:

Дебет:Өглөг /нэр төрлөөр/

ТАВДУГААР БҮЛЭГ. НАМЫН ЗАРДАЛ

Арван долоо. Намын зардал

17.1.Хөрөнгийн бууралт, эсхүл өр төлбөрийн өсөлттэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн бууралт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

17.2.Гарз гэж байгууллагын үйл ажиллагааны явцад үүсэж болох, зардлын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно.

17.3.Зардлыг төлсөн мөнгө, эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

17.4.Зардалд ажиллагсдын зардал, төрийн санхүүжилтийн дэмжлэгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан зардал, үйл ажиллагааны бусад зардал, сонгуулийн зардал, эд хөрөнгө ашиглалтын зардал, бусад зардал, гарз хамрагдана.

Арван найм. Ажиллагсдын зардал

18.1.Ажиллагсдын зардалд цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, ажилтанд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговор, хүний нөөцийн бусад зардал хамрагдана.

18.1.1.цалингийн урьдчилгаа тавьж олгосон үед:

Дебет:Цалингийн урьдчилгаа

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

18.2.2.ээлжийн амралтын цалин, шагнал урамшуулал тооцоолсон бол:

Дебет:Цалингийн зардал

Кредит:Амралтын цалингийн өр төлбөр

18.2.3.тооцоолсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос урьдчилгаа цалин болон хуулийн дагуу татвар, шимтгэлийг суутгаж, олгосон үед:

Дебет:Цалингийн өглөг

Кредит:Цалингийн урьдчилгаа

Кредит:НДШ-ийн өглөг

Кредит:ХХОАТ-ын өглөг

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

18.2.4.ажил олгогчийн төлөх эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр:

Дебет:НДШ-ийн зардал

Кредит:НДШ-ийн өглөг

18.2.5.хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох үед:

Дебет:Холбогдох зардлын данс

Дебет:Бусад авлага (НДС-аас төлөх дүнгээр)

Кредит:Ажилтанд өгөх өглөг

18.2.6.нийгмийн даатгалын сангаас тэтгэмжийг байгууллагын дансанд шилжүүлсэн бол:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит:Бусад авлага

18.2.7.тэтгэмжийг ажилтанд олгох үед:

Дебет:Ажилтанд өгөх өглөг

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Арван ес. Төрийн санхүүжилтийн дэмжлэгийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан зардал

19.1.Төрийн санхүүжилтийг Улс төрийн намын тухай хуулийн 26.3-т заасан зориулалтын дагуу зарцуулах үед:

19.1.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд;

Дебет:Нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

19.1.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад;

Дебет:улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

19.1.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд;

Дебет:судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

19.2.Төрийн санхүүжилтийн зарцуулалтыг зохион байгуулсан үйл ажиллагаа тус бүрээр тайлагнана.

Хорь. Үйл ажиллагааны зардал

20.1.Үйл ажиллагааны зардалд төрийн санхүүгийн дэмжлэгийг хуульд заасны дагуу зарцуулснаас бусад эд хөрөнгө ашиглалтын, түлш, шатахуун, тээвэр, түрээс, харилцаа холбоо, засвар, харуул хамгаалалт, аюулгүй байдал, мэргэжлийн үйлчилгээ, вэб сайт ба цахим орчин ашигласан, бичиг хэрэг, татвар, төлбөр, хураамж, албан томилолт, банкны хүү, шимтгэл гэх мэт урсгал зардал багтана. Үйл ажиллагааны зардлыг төрөл тус бүрээр ангилж, бүртгэнэ.

20.1.1.зардлыг хуримтлуулан бүртгэх үед:

Дебет:Зардлын холбогдох данс

Кредит:Өглөгийн холбогдох данс

20.1.2.хуримтлуулсан зардлыг төлж барагдуулах үед:

Дебет:Өглөгийн холбогдох данс

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

20.1.3.зардлыг шууд мөнгөөр төлөх үед:

Дебет:Зардлын холбогдох данс

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

20.1.4.албан томилолтын зардлыг холбогдох баримтад тулгуурлан дараа тайлангийн тооцоог хийх үед:

Дебет:Албан томилолтын зардал

Кредит:Дараа тайлангийн тооцоо

20.1.5.банканд төлсөн шимтгэл, хураамжийг банкны хуулга, бусад баримтыг үндэслэн:

Дебет:Банкны шимтгэлийн зардал/ Зардлын холбогдох данс

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

20.1.6.аудит, нягтлан бодох бүртгэл, хуулийн болон бусад мэргэжлийн үйлчилгээ болон хөндлөнгийн хяналтын зардлыг тэдэнтэй байгуулсан гэрээ, нэхэмжлэлийг үндэслэн

Дебет:Аудит/мэргэжлийн үйлчилгээний зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

20.1.7.урьдчилж төлсөн зардлаас тайлант үед хамаарах хэсгийг зардалд тохируулна:

Дебет:Зардлын холбогдох данс

Кредит:Урьдчилж төлсөн зардал

20.1.8.үйл ажиллагаанд хэрэглэгдэх хангамжийн зүйлс, маягтыг худалдан авч, ашиглалтад шууд тавьж олгох үед:

Дебет:Бичиг хэргийн зардал/ Зардлын холбогдох данс

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

20.1.9.харуул хамгаалалтын, аюулгүй байдлын зардлыг гэрээ, нэхэмжлэх, бусад зардлын баримтыг үндэслэн бүртгэх үед:

Дебет:Харуул хамгаалалтын, аюулгүй байдлын зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

20.1.10.шатахуун болон тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар үйлчилгээний зардлыг жолоочийн тооцоо, нэхэмжлэх, бусад баримтыг үндэслэн бүртгэхэд:

Дебет:Шатахуун, тээврийн зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

20.1.11.цахилгаан, дулаан, уур, усны төлбөрийг нэхэмжилсэн, эсхүл уг төлбөрийг төлж барагдуулах үед:

Дебет:Ашиглалтын зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад өглөг

20.1.12.барилга байгууламжид хийгдсэн урсгал засвар:

Дебет:Засварын зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө /Бусад өглөг/
холбогдох бусад данс/

20.2.Бусад зардал, хөрөнгө борлуулсан данснаас хассаны гарз, гадаад валютын ханшийн зөрүүний гарз, торгуулийн зардал, хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн гарз хамрагдана.

20.2.1.эрх зүйн маргааны улмаас нөхөн төлбөр, торгууль төлөх үед:

Дебет:Торгуулийн зардал

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны өглөг

20.2.2.үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, бусад хөрөнгийг гарзтайгаар данснаас хассан, борлуулсан үед:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Дансны авлага

Дебет:Хуримтлагдсан элэгдэл, хорогдол, үнэ цэнийн бууралт

Дебет:Хөрөнгө борлуулсан, данснаас хассаны олз

Кредит:Хөрөнгийн холбогдох данс

20.2.3.хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийг тохируулан бүртгэх үед гарз үүссэн бол:

Дебет:Хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит:Хөрөнгийн холбогдох данс

20.3.Мөнгөн зүйлсийн барагдуулалт, эсхүл мөнгөн зүйлсийн ханшийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

20.3.1.валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн хөрөнгийг бууруулж, ханшийн зөрүүний гарз бүртгэхэд:

Дебет:Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө – гадаад валют/ Авлага

20.3.2.валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн өр төлбөрийг нэмэгдүүлж, ханшийн зөрүүний гарз бүртгэхэд:

Дебет:Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит:Өглөг /нэр төрлөөр/

20.4.Гадаад валютаарх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

20.4.1.гадаад валютаарх авлагыг валютын ханш буурсан үед цуглуулсан:

Дебет:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Дебет:Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит:Авлага /нэр төрлөөр/

20.4.2.гадаад валютаарх өглөгийг валютын ханш өссөн үед төлөхөд:

Дебет:Өглөг /нэр төрлөөр/

Дебет:Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит:Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

20.5.Тайлант хугацааны эцэст орлого, зардлын дансны үлдэгдлийг орлого, зардлын нэгдсэн дансанд хааж, үр дүнг тооцон тайлант үеийн ашиг алдагдал дансанд хаалтын бичилт хийнэ.

20.5.1.орлогын дансны хаалтын бичилт:

Дебет:Орлогын холбогдох данс

Кредит:Орлого, зардлын нэгдсэн данс

20.5.2.зардлын дансны хаалтын бичилт:

Дебет:Орлого, зардлын нэгдсэн данс

Кредит:Зардлын данс

20.5.3.орлого, зардлын нэгдсэн дансны зөрүүгээр тайлангийн үеийн ашиг, алдагдлыг тодорхойлох бөгөөд дараах байдлаар бүртгэнэ:

Ашигтай бол:

Дебет:Орлого, зардлын нэгдсэн данс

Кредит:Тайлант үеийн ашиг, алдагдал

Алдагдалтай бол:

Дебет:Тайлант үеийн ашиг, алдагдал

Кредит:Орлого, зардлын нэгдсэн данс

Хорин нэг. Сонгуулийн зардал

21.1.Сонгуулийн зардалд дараах зардлыг хамааруулна:

21.1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу намаас гаргаж төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан сонгуулийн зардлын тайланд тусгасан дүн;

21.1.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу намаас гаргаж төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан сонгуулийн зардлын тайланд тусгасан дүн;

21.1.3.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу намаас төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаар хянуулсан сонгуулийн зардлын тайланд тусгасан дүн;

21.1.4.ард нийтийн санал асуулгатай холбоотой гаргасан зардал.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Хорин хоёр. Орлогын татвар

22.1.Нягтлан бодох бүртгэлийн ашиг, алдагдал (Татварын өмнөх ашиг, алдагдал) гэж санхүүгийн бүртгэлээр тооцоолж гаргасан, тайлант үеийн татварын зардлыг хасахын өмнөх ашиг, алдагдлыг ойлгоно.

22.2.Татвар ногдуулах орлого (татварын алдагдал) гэж Монгол Улсын татварын хуулийн дагуу тооцож, тухайн дүнгээс тайлант үед төлөх орлогын албан татварыг тооцох орлогыг хэлнэ.

22.3.Татварын түр зөрүү гэдэг нь татварын хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэл ба татварын суурийн хоорондох зөрүүг хэлнэ. Түр зөрүүний нөлөөг

хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансанд бүртгэнэ. Түр зөрүү нь татвар ногдох түр зөрүү ба хасагдах зөрүү гэсэн хоёр хэлбэртэй.

22.4.Татварын түр зөрүү дараах тохиолдолд үүснэ. Үүнд:

22.4.1.санхүүгийн тайлагнал ба татварын зорилгоор хөрөнгийн элэгдлийн арга, зарчим, хугацаа өөр байх

22.4.2.нөөц байгуулсан зардлыг татварын зорилгоор татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй байх

22.4.3.хөрөнгийн үнэ цэнийн бууралт, хөрөнгийг данснаас хассанаас үүсэх зардлыг татварын зорилгоор татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй байх

22.4.4.мөнгөн зүйлсийн үлдэгдэлд валютын ханшийн тэгшитгэл хийснээс үүсэх валютын ханшийн хэрэгжээгүй олз, гарз

22.4.5.татварын хуулиар тогтоосон хязгаарлалтыг давсан урсгал засварын зардал

22.4.6.татварын албаар баталгаажуулсан татварын тайлангаарх алдагдлыг дараагийн үед шилжүүлэн тооцох

22.4.7.санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт

22.4.8.СТОУС-ын дагуу хийх залруулгууд

22.5.Татвар ногдох түр зөрүү гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогыг нэмэгдүүлэх нөлөө үүсгэх түр зөрүү юм. Татвар ногдох түр зөрүү үүссэн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөрийг заавал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

22.6.Хасагдах түр зөрүү гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогыг бууруулах нөлөө үүсгэх түр зөрүү юм. Хасагдах түр зөрүүг ирээдүйд нөхөх боломжтой үед хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

22.7.Хойшлогдсон татварын хөрөнгө ирээдүйд нөхөгдөх боломжтой эсэхийг үнэлэхдээ ирээдүйд татвар ногдуулах хангалттай хэмжээний орлого (хасагдах түр зөрүүний ирээдүй үеийн буцаалтыг оролцуулалгүйгээр) олох эсэх буюу ирээдүйн тайлант үед олох хүлээгдэж буй татвар ногдуулах орлогын төсөөлөлд үндэслэнэ. Тухайлбал, дараагийн тайлант үеүдэд алдагдалтай ажиллах магадлалтай байгаа нөхцөлд хасагдах түр зөрүү нөхөгдөхгүй тул хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй.

22.8.Татвар ногдох ба хасагдах түр зөрүүг үүсэх нөхцөл байдал нь:

	Хөрөнгийн хувьд	Өр төлбөрийн хувьд
Дансны үнэ > Татварын суурь	Татвар ногдох түр зөрүү үүснэ	Хасагдах түр зөрүү үүснэ
Дансны үнэ < Татварын суурь	Хасагдах түр зөрүү үүснэ	Татвар ногдох түр зөрүү үүснэ

22.9.Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг.

22.10.Тайлант хугацаанд хамаарах орлогын албан татварын өглөгийг тайлант хугацааны эцсээр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр татварын эрх бүхий байгууллагад төлөх, хүлээн авах дүнгээр хэмжинэ.

22.11.Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглан тооцоолно.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр = Татвар ногдох, эсхүл хасагдах түр зөрүү × Татварын хувь хэмжээ

22.12.Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн эцсийн үлдэгдэл ба эхний үлдэгдлийн зөрүүгээр хойшлогдсон татварын зардал, орлогыг тооцоолж, хэмжинэ.

22.13.Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны өсөлт, хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны бууралтыг хойшлогдсон татварын орлогод бүртгэнэ. Харин хойшлогдсон татварын хөрөнгийн дансны бууралт, хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны өсөлтийг хойшлогдсон татварын зардалд бүртгэнэ.

22.14.Тайлант үеийн татварыг дараах байдлаар бүтгэнэ:

22.14.1.орлогын албан татварыг урьдчилж төлөхөд татварын авлага дансанд бүртгэнэ.

Дебет: ААНОАТ-ын авлага

Кредит: Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

22.14.2.хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээгээр тооцоолсон тайлант хугацаанд хамаарах татварыг ААНОАТ-ын өглөгт бүртгэнэ.

Дебет: Тайлант үеийн орлогын албан татварын зардал

Кредит: ААНОАТ-ын өглөг

22.14.3.татварын авлага, өр төлбөрийг нэгтгэн цэвэр дүнг тодорхойлохдоо:

Дебет: ААНОАТ-ын өглөг

Кредит: ААНОАТ-ын авлага

22.15.Хойшлогдсон татварыг дараах байдлаар бүтгэнэ:

22.15.1.татвар ногдох түр зөрүү үүсвэл хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын өглөг

22.15.2.хойшлогдсон татварын өглөгийг буцаах үед:

Дебет: Хойшлогдсон татварын өглөг

Кредит: Хойшлогдсон татварын зардал, орлого

22.15.3.ирээдүйд нөхөгдөх боломжтой хасагдах түр зөрүү үүссэн үед:

Дебет: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал, орлого

22.15.4.хойшлогдсон татварын хөрөнгийг буцаах үед:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

22.15.5.дараа жилүүдэд шилжүүлэх татварын тайлангаарх алдагдлын хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө:

Дебет: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал, орлого

22.15.6.татварын тайлангаарх алдагдлыг дараа жилүүдэд шилжүүлэх үед:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

22.15.7.дараа жилүүдэд шилжүүлэлгүй үлдсэн татварын тайлангаарх алдагдлыг буцаахдаа:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

“Улс төрийн намын намын санхүүгийн
тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө,
орлого, зарлагын ангиллыг
тодорхойлон тайлагнах журам”-ын
нэгдүгээр хавсралт

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА БЭЛТГЭХ ЗААВАР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Намын нийтлэг зориулалттай иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө.

1.2. Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөгөөр илэрхийлсэн ба тус журам болон СТОУС-н дагуу тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна.

1.3. Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн тайлан, бусад мэдээ баримтыг тогтсон загварын дагуу үнэн зөв бэлтгэж, заасан хугацаанд багтаан гаргах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу намын дарга, санхүү хариуцсан удирдах ажилтан хүлээнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

Санхүүгийн тайлан, түүний зорилго

